



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцийн 9 дүгээр зүйлийн 9.2f дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэдээлэл, лавлагаа тусламжийн шууд утасны судалгаа хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч

Б.Хурцэцэг ХБХХЕГ-ын Тамгын газрын дарга

Гишүүд

Ж.Хаш-Эрдэнэ ХБХХЕГ-ын Ерөнхий нягтлан бодогч

Д.Нандин-эрдэнэ ХБХХЕГ-ын Мэдээлэл, технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Д.Энхтүвшин ХБХХЕГ-ын Хэвлэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

Б.Нямцэцэг ХБХХЕГ-ын Төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн

Ц.Ананд ХБХСЗХТ-ийн мэдээлэл технологийн инженер

С.Бямбадэлгэр СЗСҮТ-ийн МБУЧОС-ийн дохионы орчуулагч багш

Л.Зулцэцэг АХБ, ХБИОХЧС-төслийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга

Б.Цэвэлмаа

ХБХХЕГ-ын гадаад харилцааны мэргэжилтэн

2. ХБИ-ийн лавлах утасны үйлчилгээний судалгаа хийх ажлын удирдамж боловсруулах, тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг гаргах ажлыг чанартай, хариуцлагатай зохион байгуулахыг Ажлын хэсгийн гишүүдэд, хэрэгжилтийн явц, үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /Б.Хурцэцэг/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Ц. ГАНЧИМЭГ



1118270630
6388403 & 63884120